



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

“ТӨРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ: ШУДАРГА СОНГУУЛЬ” ФОРУМААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хот

2007-12-12

УИХ-ын болон орон нутгийн ээлжит сонгууль хаяанд ирсэн энэ үед сонгууль шударга явагдах үндсэн нөхцөл болох ил тод байдлын талаар төр засаг, иргэний нийгэм, улс төрийн намуудын төлөөлөл хамтран хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох нь чухал гэж үзэн Нээлттэй Нийгэм Форумаас “Төрийн ил тод байдал: Шударга сонгууль” үндэсний форумыг 2007 оны 12 дугаар сарын 12-нд зохион байгууллаа. Энэхүү форумд хот, хөдөөгийн 200 гаруй төлөөлөгч оролцож сонгуулийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, сонгуулийн үйл явцад иргэний нийгмийн хяналт, сонгуулийн байгууллагын хараат бус байдал гэсэн сэдвүүдээр санал бодлоо солилцов. Форумд оролцогчдоос хууль тогтоох болон санаачлах байгууллага, сонгууль эрхэлсэн байгууллага, улс төрийн намуудад хандан сонгуулийн ил тод байдлыг хангахын тулд нэн даруй авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар дараахь санал зөвлөмжийг гаргалаа.

Нэг. Сонгуулийн явцыг ил тод, хяналттай байлгах:

1. Сонгуулийн үйл явцад хөндлөнгийн **ажиглалт** хийх хүсэлт гаргасан иргэний нийгмийн байгууллагуудыг олон улсын жишгээр тодорхой журмын дагуу магадлан итгэмжилж, ажиглагчаар оролцох эрхийг нээх, үүний тулд УИХ-ын сонгуулийн /УИХС/ тухай хуулийн 9.2-ын сонгууль бэлтгэн явуулах ажил ил тод байна гэсэн заалтад нийцүүлэн 46.1 заалтад иргэний нийгмийн байгууллага ажиглагч томилж ажиллуулж болно гэж нэмж оруулах,
2. Сонгуулийн ажиглагчийн эрхийг өргөтгөж сонгуулийн маргаан шийдвэрлэхэд хамааруулах,
3. Сонгуулийн хуулийн 20.8-д заасан **сонгогчдын нэрийн жагсаалтыг** хувилж олшруулах, тараахыг хориглоно гэсэн заалтыг өөрчлөх, сонгуулийн мониторинг хийж буй иргэний нийгмийн байгууллагуудад сонгогчийн нэрийн жагсаалтыг хангалттай хугацааны өмнө хувилж өгөх, ингэснээр үнэн зөвийг нягтлах, хяналт тавих бололцоог бий болгох,

4. УИХС-ийн тухай хуулийн 21.1-д сонгогчийг нэрийн жагсаалтын тухайд зөвхөн сонгогч өөрөө юмуу, сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч тухайн хэсгийн хороонд гомдол гарган, өөрчлөлт оруулахаар шаардах эрхтэй байхаар хязгаарласныг ажиглагч хийхээр магадлан итгэмжлэгдсэн болон сонгуулийн мониторинг хийж буй иргэний нийгмийн байгууллага мөн гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй болгон өөрчлөх,
5. УИХС-ийн тухай хуулийн 20.2-т сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн хорооны байранд ил тавихаар заасан дээр нэмж уг жагсаалтыг СЕХ-ны вэб хуудсанд байрлуулах шаардлагыг тусгах, түүнчлэн санал хурааж дууссаны дараа дээрх нэрийн жагсаалтад байгаа сонгогчдын нэрсийг санал өгсөн, өгөөгүйгээр нь ялгаж хуваан иргэдэд үнэн зөвийг нягтлан хянах бололцоог нээх,
6. Хэсгийн хороодоос зохион байгуулдаг сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, нэгтгэх ажлын хэсэгт иргэний нийгмийн төлөөлөл, сонирхогч талуудыг оролцуулах боломжийг СЕХ журмаар бий болгох,
7. **Саналын хуудсыг** хэвлэх, хүргэх, гарын үсэг зурж тэмдэг дарах, зарцуулах, хадгалах үйл явцыг хянах бололцоог иргэний нийгмийн байгууллага, тэдний томилсон ажиглагчдад олгох асуудлыг журамлах,
8. **Санал авах, санал тоолох**, зөөврийн хайрцгаар санал авах, **санал хураалтын дүнг зарлах** үйл явцыг бүхэлд нь хянах бололцоог иргэний нийгмийн байгууллага, тэдний томилсон ажиглагчдад хуулиар олгох,
9. **Сонгуулийн дүнг** гармагц хэсгийн хорооны протоколыг хэсгийн байранд ил байрлуулж, сонгуулийн ажиглагчдад хуулбарыг олгохоор СЕХ журамдаа тусгах.

Хоёр. Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах:

10. Сонгуулийн санхүүжилтыг хянахад ашигладаг бүртгэлийн маягтуудыг ардчилсан сонгуульд баримталдаг олон улсын жишгийн дагуу боловсруулан баталж мөрдүүлэх,
11. УИХС-ын тухай хуульд зааснаар сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор СЕХ-нд ирүүлэхээр заасан нь хангалтгүй учир сонгуулийн кампанит явцад тодорхой хуваарь гарган уг дансанд хяналт тавих, итгэмжлэгдсэн аудиторчдоор шалгуулах, илэрсэн зөрчил болон тэдгээрийн дагуу авсан арга хэмжээг нам, эвсэл, нэр дэвшигч бүрээр гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд шуурхай мэдээлж байх,
12. “Сонгогчийн санал худалдан авах” тухай ойлголтыг хуулинд тодорхойлж, ийм үйлдэлд тооцох хариуцлагыг хуульчлах,

13. Сонгуулийн кампанит ажлын санхүүжилт, зардлын тайлан гаргахтай холбоотой хуулийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд нам, эвсэл, нэр дэвшигчдийн хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх
14. СЕХ сонгуулийн зардлын тайланг хянан үзэж санал хурааж дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг зөвхөн өдөр тутмын сонинуудад нийтэлдэг байх биш, хөндлөнгийн хяналтыг үр дүнтэй, олон нийтэд ил тод болгох үүднээс зардлын тайланг сонирхсон этгээд хэдийд ч хуулан авч нийтийн хүртээл болгох, СЕХ өөрөө интернетэд тухай бүр нь албан ёсоор байрлуулдаг байхыг хуульчлах.

Гурав. Сонгуулийн байгууллагын хараат бус, нээлттэй байдлыг хангах:

15. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.2-т заасан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн төрийн жинхэнэ албан хаагч байх гэсэн шалгуурыг өөрчилж, төрийн жинхэнэ алба бүрэн утгаараа төлөвшөөгүй өнөөгийн нөхцөлд Сонгуулийн төв байгууллагыг төр барьж буй намын нөлөөллөөс хараат бус байлгахын тулд улс төрийн намуудын төлөөллийг тэнцвэртэй оруулах,
16. Цаашид сонгуулийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг жинхэнэ утгаараа бие даасан хараат бус байх шаардлагад нийцүүлэн олон нийтийн оролцоотой хэлэлцэн шинэчлэх,
17. Сонгуулийн шат шатны хороодыг байгуулах, бүрэлдэхүүнийг томилох үйл явцыг ил тод, нээлттэй байлгах, уг асуудлыг шийдвэрлэх хурлын товыг олон нийтэд ил тод зарлаж, хөндлөнгөөс ажиглах боломж олгох, хурлын протокол, шийдвэр, томилогдсон хэсгийн хороодын бүрэлдэхүүн, намын харъяалал зэргийн талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй зарлах.
18. Сонгуулийн бүх шатны байгууллагын шийдвэр гаргах үйл явцын нээлттэй байдлыг хангахын тулд хурлын тов, хэлэлцэх асуудал зэргийг хуралдаан болохоос 5, яаралтай үед 2-с доошгүй хоногийн өмнө нийтэд урьдчилан мэдээлэх, иргэд оролцох нөхцлийг бүрдүүлэх, энэ талаар холбогдох сонгуулийн байгууллага нь дэгэндээ тодорхой тусгах,
19. Сонгуулийн бүх шатны байгууллагын аливаа шийдвэр, протокол, бичиг баримтыг ажлын 3-5 хоногт багтаж олон нийтэд ил тод болгох, нэгтгэж хэвлэх, вэб сайтад байрлуулах. Үүнд сонгуулийн явцад тэмдэглэгдсэн зөрчлийн жагсаалт, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн санал хураалт, гишүүдийн санал, байр суурь, асуудлыг шийдвэрлэсэн дүн, дэлгэрэнгүй протоколыг хөтөлж нээлттэй болгох,

Түүнчлэн Форумд оролцогчид ардчилсан нийгэмд сонгуулийн хууль нь иргэдийн улс төрийн үндсэн эрхийг хангахад Үндсэн Хуулийн дараа орох томоохон хууль мөн учраас сонгуулийн хууль, дүрэм, журмыг санаачлах, боловсруулах, батлах, өөрчлөлт оруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах нь чухал гэдгийг онцлон тэмдэглээд түүнээс гадна хэдэн хэдэн тодорхой асуудалд төрийнхний анхаарлыг хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

Тухайлбал, УИХ-аар хэлэлцэгдэх гэж буй сонгуулийн системийг шинэчлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ Үндсэн хуульд нийцүүлэх, ингэхдээ тэдний өргөн оролцоо, үндэслэл бүхий судалгаа, олон талт хэлэлцүүлэгт үндэслэх, эдгээрт хангалттай хугацаа өгч, нухацтай хандах шаардлагатайг онцлов. Тэрчлэн сонгогчдын боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг өргөтгөн, түүнд зориулан СЕХ-д олгож буй төсвийг нэмэгдүүлэх, цаашид сонгуулийн хуулийг нэг мөр цэгцлэх, ингэхдээ бие даасан УИХ-ын, орон нутгийн Хурлын, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулиудаас гадна бүх сонгуульд баримтлах, гол зарчмуудаа тусгасан ерөнхий нэг сонгуулийн хуультай болох нь зүйтэй гэх зэрэг асуудлуудыг дэвшүүллээ.

ФОРУМД ОРОЛЦОГЧИД